

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.19 №34 (34)

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМД ХООРОНДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛОВ

Монгол Улсын Батлан хамгаалах яам, БНЭУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын 10 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт 4 дүгээр сарын 16-нд цахимаар зохион байгуулагдав.

Зөвлөлдөх уулзалтыг Монголын талаас БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг, Энэтхэгийн талаас БХЯ-ны Нэгдсэн нарийн бичгийн дарга Шри Вишал Гаган нар удирдаж, хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд цэргийн боловсон хүчин бэлтгэх, хамтарсан дадлага сургууль хийх, кибер аюулгүй байдал, мэдээлэл, технологийн чиглэлийн ажиллагааг идэвхжүүлэх талаар санал солилцож, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, чиглэлийг тодорхойллоо.

Уулзалтад БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх оролцсон бөгөөд батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь Монгол, Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцаанд чухал байр суурь эзэлдэг болохыг онцлов.

БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг хоёр тал



дэлхий нийтээр тархаад буй СО-VID-19 цар тахлын хүнд хэцүү үеийг даван туулахад хамтран ажиллаж, тэр

дундаа Энэтхэг Улсын Засгийн газраас манай улсад коронавирус эсэргүүцэх вакцин нийлүүлсэн нь Монгол Улсын

хувьд энэхүү цар тахлыг хязгаарлах, даван туулахад чухал хувь нэмэр оруулж буйд талархал илэрхийлэв.

“ЭРДМИЙН БАГА ЧУУЛГАН-2021” АМЖИЛТТАЙ БОЛЛОО



ҮБХИС
ҮБХИС-ийн ЦНДС-ийн багш, сонсогчдын “Эрдмийн бага чуулган-2021” эрдэм шинжилгээний хурал өнгөрсөн долоо хоногт онлайн хэлбэрээр боллоо.

Энэ үеэр тэнхим бүрээс шалгарсан багш, сонсогч нар тус бүр нэг илтгэл тавьж, инновацын бүтээлээ товч танилцуулав. Чуулганы төгсгөлд багш нараас тэргүүн байрт АЦ-ийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа Ц. Дунгармаагийн “Цахим

хичээл зохион байгуулалтад хийсэн дүн шинжилгээ” илтгэл, дэд байрт ЦИХТ-ийн багш, ахмад Б.Баярбаясгалангийн “Цэргийн зам барих ажлыг сайжруулах технологид хийсэн судалгаа” шалгарсан бол гутгаар байрт ЦХКАБ-ын тэнхимийн багш, ахлах дэслэгч С.Билэгтийн “Кибер аюулгүй байдал мэргэжлээр олон улсын сертификат олгох сургалтыг зохион байгуулах боломж” илтгэлийг тус тус шалгаруулав.

Сонсогчдоос тэргүүн байрт ЦАТ-ийн тэнхимийн IV дамжааны сонсогч

Х.Түмэндэмбэрэлийн “Био хийг цэргийн гал тогоонд ашиглах боломжийн судалгаа” илтгэл, дэд байрт ЦХКАБ-ын тэнхимийн IV дамжааны сонсогч Д.Ууганбатын “Байгууллагын дотоод сүлжээнд халдлага илрүүлэх” илтгэл, гуравдугаар байрт АХТ-ын тэнхимийн III дамжааны сонсогч Н.Идэрхангайгийн “Халхын голын дайнд ХТТ-ийг хэрэглэсэн туршлага” илтгэл шалгарсан юм. Энэ жилийн ЦНДС-ийн эрдмийн чуулганы инновацын шилдэг бүтээлээр ЦХКАБ-ын тэнхимийн

багш, дэд хурандаа З.Нарангэрэлийн “Сургалтын үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн хөгжүүлэлт” бүтээл шалгарч, Артиллер зэвсгийн тэнхимийн багш, ахмад Б.Лхагважавын “Артиллерийн буудлагын тавилт тодорхойлох ажиллагааг автоматжуулах арга зам”, ЦИХ-ийн тэнхимийн багш, ахмад У.Мөнхбатын “Монгол Улсын цацрагийн цагийн байдлыг үнэлэх арга зүйг боловсронгуй болгох нь” бүтээл удаах байруудыг эзэллээ. Сонсогч нарын инновацын шилдэг бүтээлээр АЦ-ийн тэнхимийн сонсогч М.Энхсаруул, Ц.Хас-Очир, Б.Баясан нарын “Цэргийн зориулалттай роботыг Монгол Улсын Зэвсэгт хүчинд нэвтрүүлэх боломж судалгаа” бүтээл тус тус шалгарлаа.

БХЯ-ны ШУТ-ийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Содномцог, ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Ж.Цэрэнчимэд, ҮБХИС-ийн Сургалтын хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа Б.Мандахбаяр, БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор, хурандаа Т.Соронзонболд нар урилгаар оролцож, чуулганд оролцогчдоос асуулт асууж, санал зөвлөгөө өглөө.

ЦНДС-ийн Эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа И.Батсайхан, ЭШСА-ны мэдээлэл, сургалт, арга зүйн мэргэжилтэн доктор (Ph.D), Д.Энх-Амгалан нарын удирдсан уг хуралд тус сургуулийн 53 багш, 31 сонсогч оролцсон юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	☁️ 7

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.363.00	3.474.00
CNY 🇨🇳	434.50	439.40
RUB 🇷🇺	36.60	39.10
JPY 🇯🇵	25.72	26.60
KRW 🇰🇷	2.42	2.65

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 7
2021.04.19.
/ДАВАА ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН НЭГ ЦАГААН ХӨХ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ.

Наран ургах, шингэх:

05.55-19.47

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Уул.

Аргын тооллын 4 дүгээр сарын 19, Сумъяа гараа. Билгийн тооллын 7, Өглөгт охин одтой, улаагчин тахиа өдөр. Өдрийн наран 5 цаг 55 минутад мандан, 19 цаг 47 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр архи уух, тэмх татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба гараагийг тахиж, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хинцүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсоод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

20.655+1340

ЭДГЭРСЭН

11.877

НАС БАРСАН

44/6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1744(8)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ

293

ЭДГЭРСЭН

1456

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 139,501,934

Эдгэрсэн

Нийт: 113,372,142

Нас барсан

Нийт: 2,992,193



ЦАХИМ ШУУДАНД

М.ДӨЛГӨӨН АЛТАН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Зэвсэгт хүчний 337 дугаар анги

Казахстан Улсын Алматы хотод зохиогдсон Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн тамирчин ОУХМ М.Дөлгөөн 55 кг-ын жинд аваргын алтан медаль хүртлээ.

Эмэгтэйчүүдийн баг тамирчид маань Алматыгийн дэвжээнээс хоёр алт, дөрвөн мөнгө, нэг хүрэл, нийт долоон медальтайгаар тэмцээнээ өндөрлүүлэв. Тодруулбал, 55 кг-ын жинд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн тамирчин ОУХМ Мөнхболдын Дөлгөөн, 65 кг-ын жинд "Хилчин" спорт хорооны тамирчин ОУХМ Зоригтын Болортунагал нар түрүүлж, алтан соёмбот далбаагаа мандуулж, төрийн дууллаа эгшиглүүлсэн бол 57 кг-ын жинд "Хасу-Мегастарс" клубийн тамирчин ОУХМ Алтанцэцэгийн Батцэцэг, 59 кг-ын жинд "Аврагч" спорт хорооны тамирчин ОУХМ Б.Шоовдор, 62 кг-ын жинд "Аврагч" спорт хорооны тамирчин ОУХМ Х.Болортуяа, 68 кг-ын жинд "Хасу-Мегастарс" клубийн тамирчин ОУХМ Э.Дэлгэрмаа нар мөнгө, 72 кг-ын жинд "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ Э.Цэвэгмид нар хүрэл медалийн эзэд боллоо. Монголын эмэгтэй бөхчүүд багийн дүнгээр түүхэндээ анх удаа тэргүүлсэн. Тэгвэл манайхнаас ердөө таван оноо дутсан Энэтхэгийн бөхчүүд (4 алт+1 мөнгө+2 хүрэл) аман хүзүүдэж, зохион байгуулагч орон Казахстан (2+1+4) гутгаар байрт оров. Эмэгтэй бөхчүүдийн рейтингээрээ дэлхийд тэргүүлэгч Япон, БНХАУ, БНАСАУ-ын эмэгтэй бөхчүүд тодорхой шалтгаанаар энэ удаагийн Азийн аваргын тэмцээнийг өнжсөн юм.

Тус тэмцээнээс алтан медаль



хүртсэн Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн тамирчин М.Дөлгөөн нь 2016 оны 11 дүгээр сард Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн аэродромын үйлчилгээний ротын жолоочоор томилогдон ажиллаж байгаа юм. 2011 оноос эхлэн чөлөөт бөхийн спортоор хичээллэж эхэлсэн бөгөөд 2014 онд спортын мастер, 2015 онд Олон улсын хэмжээний мастер цолны болзлыг биелүүлжээ. Түүний амжилтаас



дурдвал, Өсвөрийн залуучуудын улсын 4 удаагийн аварга бөгөөд 2013 оны Ази тивийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль, БНХАУ-ын "Наньжин-2014" Залуучуудын зуны II олимпын мөнгөн медаль, 2018 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний алтан медаль, 2019 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медаль, 2019 оны "Монголиа Опен" олон улсын Гран-При тэмцээний алтан медаль, 2019 оны насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль, 2020 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний алтан медаль, 2020 оны насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медальт тамирчин юм. Тэрбээр Азийн аварга шалгаруулах тэмцээнээс сүүлийн 3 жил медалийнхаа өнгийг хувиргаж, Монгол Улсаас Ази тивийн аваргын алдрыг хүртсэн 23 дахь, эмэгтэй бөхчүүдээс 9 дэх тамирчин боллоо.

ЭХ ОРНЫ ХӨВГҮҮДДЭЭ АЛБАА НЭР ТӨРТЭЙ ХААХЫГ ЗАХИЛАА



Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус Цэргийн штаб Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд 2020 оны хоёрдугаар ээлжээр цэргийн албанд татагдсан дайчдыг цахимаар болон утсан холбоогоор аав ээж, ах дүү нартай нь холбох ажлыг хамтран явуулав. Тусээлжийн цэрэг татлагаар Төв аймгийн Зуунмод, Архуст, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Батсүмбэр, Баянжаргалант, Мөнгөнморьт, Эрдэнэ зэрэг сумаас цэргийн албанд татагдсан дайчид цахим болон үүрэн холбоогоор холбогдсон юм.

байгааг хараад, хөвгүүддээ албаа нэр төртэй хаахыг захив. Цар тахлын нөхцөл байдлын улмаас үр хүүхдүүдээ эргэж тойрч чадахгүй байгаа эцэг эхчүүдийг хугацаат цэргийн алба хаагчтай холбох ажлыг зохион байгуулсанд ар гэрийнхний зүгээс талархаж цаашид тус арга хэмжээг тогтмол зохион байгуулж байхыг хүслээ.

Цахим уулзалтын төгсгөлд цэргийн албаа хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчид нутгийн дүү нартаа хандаж "Удахгүй цэрэг татлага орон даяар явагдана. Дүү нар минь цэргийн алба хаагаарай. Үнэхээр их зүйлийг сурч, мэдэж байна.




Уулзалтын үеэр аймаг, орон нутгийн удирдлага, нэгтгэлийн удирдлага цэргийн албан хаагчдын ар гэрийнхэнд хандан үг хэлж, хугацаат цэргийн алба хаагчдад хандан албаа нэр төртэй хааж өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөж, аав ээжийнхээ ачийг хариулахыг захилаа. Тус арга хэмжээнд оролцсон эцэг эхчүүд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, үр хүүхдээ өнгөлөг

Цэргийн эрдэмд шамдан суралцаж, эх орноо батлан хамгаалах иргэнийхээ үүргээ биелүүлээрэй" хэмээн уриалж байлаа. Мөн энэ өдөр Аймгийн онцгой комисс, Цэргийн штабаас Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хамт олонд дархлаагаа дэмжихэд дэмжлэг үзүүлж витаминь багц гардуулж, чин сэтгэлийн талархал дэвшүүлээ.

Ахмад С.СОЛОНГО

“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ЖЕНДЕРИЙН ТУХАЙ” ЦАХИМ СУРГАЛТ БОЛОВ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Хан-Уул дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Зэвсэгт хүчний 326 дугаар анги хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн тус хэлтсийн залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Азжаргал офицер, ахлагч нарт "Гэр бүлийн хүчирхийлэл, жендерийн тухай" сэдвээр цахим сургалтыг явууллаа.

Сургалтаар жендерийн тухай ойлголт, жендерийн ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүд, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх арга техник, хайрын 5 хэлийн талаар сонирхолтой лекцийг хүргэсэн нь алба хаагчдад хөл хорионы үед ар гэртээ илүү их анхаарал, халамж тавих, гэр бүлийн уур амьсгалаа сайжруулах, тэдэнтэй илүү их ярилцаж, ойлголцох сэдлийг төрүүлсэн юм.

15 КМ-ИЙН ЯВГАН МАРШИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон салбаруудын жигдрэлтийг хангах, бие бүрэлдэхүүнд бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах зорилгоор ангийн байнгын байрлал, буудлагын талбай, Бөхөг цагаан толгой, Нэргүй өндөрлөг, Ангийн байнгын байрлал гэсэн маршрутаар тактик тусгай бэлтгэлийн 15 км-ийн явган маршийг энэ сарын 16-нд явууллаа.

Маршийн явцад тактикийн ажиллагаа, буудлагын дасгал боловсруулах, химийн норматив, байр зүйнцэгүүдийг гурьдчилан бэлтгэж, тактикийн ажиллагааг ажиллагааны офицер, хошууч Э.Баяр-Эрдэнэ, химийн нормативийг ажиллагааны офицер, ахмад Б.Ганцог, химийн техник хэрэгслийн нярав-засварчин, ахлагч Т.Дамдинбазар, буудлагын дасгалыг зөвсгийн албаны дарга, хошууч З.Ариунболд, байр зүйг байр зүйн дарга, хошууч О.Мөнхбилэг нар хариуцан явуулав.

Хошууч Ө.НАРАНТУЯА

ОХУ-Д КОРОНАВИРУСИЙН МУТАЦАД ОРСОН ХУВИЛБАРЫН 81 ТОХИОЛДОЛ БҮРТГЭГДЖЭЭ



ОХУ-д Их Британийн гэгдэх коронавирусийн мутацид орсон хувилбарын 81 тохиолдол бүртгэгджээ. Энэ талаар тус улсын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах "Роспотребнадзор" байгууллагын тэргүүн Анна Попова мэдэгдсэн байна. Тэрээр "Өнөөдрийн байдлаар Их Британийн гэгдэх коронавирусийн омгийн 81, Өмнөд Африкийн

зургаан тохиолдол бүртгэгдээд байна. Энэ нь бид дэлхийн бусад улс орнуудтай "хавьталд" орж байна гэсэн үг. Бүх тохиолдол зөвөрлөгдсөн. Одоо Европ, Ази, Өмнөд Африк, Африкийн орнуудад өргөнөөр тархаж байна. ОХУ-д хязгаарлалт тогтоосноор Их Британийн гэгддэг вирусийн омгийн тархалт харьцангуй багассан. Тиймээс онцын шаардлагагүй бол хилийн дээс алхахгүй байхыг зөвлөө" гэжээ.

Мөн тус улсын газар нутагт илэрсэн мутацлагдсан шинэ хувилбарыг судалж байгаа аж.

Эх сурвалж: ТАСС